



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/152

Арвайхээр сум

「 Бүрд сумын Засаг даргын Тамгын газрын
бүтэц, орон тооны дээд хязгаарыг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.2.12 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүрд сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоож, хавсралтаар баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Бүрд сумын Засаг дарга (З.Оюундулам)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Бүрд сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/833 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

Т. Монголрууц
Албан бичгийн газруу
хяналтан ажиллах
Засаг дарга 2025.03.14

Аймгийн Засаг даргын 2025 онь 02 дугаар
сарын 28 ны өдрийн 715 дугаар
захирамжийн хавсралт



БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ,
ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
Сумын удирдлага			
1	Засаг дарга	Улс төр	1
2	Засаг даргын орлогч	Улс төр	1
Сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчид			
3	Тамгын газрын дарга	Ахлах түшмэл, ТЗ-5	1
4	Төсвийн ерөнхий нягтлан бодогч	Дэс түшмэл, ТЗ-7	1
5	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-8	1
6	Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-9	1
7	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-9	1
8	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Улсын байцаагч)	Дэс түшмэл, ТЗ-9 (Улсын байцаагч ТЗ-7)	1
9	Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн (Улсын байцаагч)	Дэс түшмэл, ТЗ-9 (Улсын байцаагч ТЗ-7)	1
10	Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-9	1
11	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-9	1
Нийт			9
Багийн Засаг даргын ажлын алба			
12	Багийн Засаг дарга	Улс төр	5
Нийт			5
Нийт дүн			16

-оОо-



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/196

Арвайхээр сум

「 Бүрд сумын Засаг даргын Тамгын газрын
төрийн үйлчилгээний албан хаагчдын орон
тооны дээд хязгаарыг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.2.12 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүрд сумын Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг тогтоож, хавсралтаар баталсугай.

2.Энэхүү захирамжийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Бүрд сумын Засаг дарга (З.Оюундулам)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

3.Шинээр 1 орон тоо (Үйлчлэгч)-г нэмэгдүүлэхэд шаардагдах цалингийн санг 2024 оны батлагдсан төсөвтөө багтаан зохицуулж шийдвэрлэх, 2025 оны төсөвтөө тусган хэрэгжүүлж ажиллахыг Бүрд сумын Засаг дарга (З.Оюундулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар
сарын 19-ны өдрийн 11/46 дугаар
захирамжийн хавсралт



**БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧДЫН ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР**

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Нягтлан бодогч	ТҮМ-7	1
2	Архив, бичиг хэргийн эрхлэгч	ТҮМ-3	1
3	Нярав	ТҮ-4	1
4	Үйлчлэгч	ТҮ-1	1
5	Жолооч	ТҮ-3	1
Нийт дүн			5

-оОо-